# ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/102 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6.1.7, 7.3.3, 14 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам"-ын 1.5 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг нэгдүгээр, хэрэглэгчдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв /хурандаа А.Алтанбагана/, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга /бригадын генерал Б.Ууганбаяр/, системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн захирал /хурандаа Ж.Амгалан/-д тус тус даалгасугай.

ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

9021120435
9129146 Б СБТ17150

000001087

g;/2023/1,2/tushaal-2023-1,2.docx

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны .1. дугаар сарын .10.-ны өдрийн
А/102 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагааг зохицуулах журам

### Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6.1.7, 14 дүгээр заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам", Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 22 тоот тушаалаар батлагдсан "Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар аргазүй"-ыг албан үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжилтийг хангах зорилгоор үндэсний хэмжээнд "Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн систем"-д нэвтрэх эрх бүхий хэрэглэгчдийн ажил үүргийн хуваарь, тэдгээрийн систем дээр хийгдэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. "Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээний мэдээллийн нэгдсэн систем" /цаашид систем гэх/ гэж гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, үүссэн нөхцөл байдал, учирсан хохирол, хэрэгцээний мэдээллийг бүртгэж гамшгийн статистик мэдээллийн санг бүрдүүлэх зориулалт бүхий программ хангамж, сүлжээ болон техник хангамжийн нэгдлийг;

1.2.2. "Системийн администратор/үндсэн зохицуулагч/" нь Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Мэдээллийн технологи, инновацын төв байх бөгөөд системийн *найдвартай ажиллагааг хангаж удирдан зохион байгуулна;*

1.2.3. "Системийн үндсэн хэрэглэгчид " гэж системд нэвтрэх эрх бүхий төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын анги, салбарын эрх бүхий алба хаагч, мэргэжилтнийг;

1.2.4. "Ажил үүргийн хуваарь" гэж систем дээр хийж гүйцэтгэх ажлын үүрэг даалгаврыг;

1.2.5. "Ажил үүргийн ангилал" гэж системд нэвтрэх эрх бүхий албан тушаалтны систем дээр хийж гүйцэтгэх ажлыг заагласан бүлгийг;

1.3. Тус систем нь дараах хоёр төрлийн дэд системээс бүрдэнэ. Үүнд:

1.3.1. "Гамшиг, түргэн тусламжийн дуудлага мэдээллийн бүртгэл, тээврийн хэрэгслийн хяналтын дундын мэдээллийн систем", үндсэн хэрэглэгч нь төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын холбоо зарлан мэдээлэл хариуцсан оператор, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн алба хаагч, ажилтнууд байна.

1.3.2. "Гамшиг аюулт үзэгдэл, ослын бүртгэл, хохирол, хэрэгцээний мэдээллийн систем", үндсэн хэрэглэгч нь төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын эрх олгогдсон гал, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, бүлгийн дарга, мэргэжилтнүүд байна.

### Хоёр: Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн удирдлага, зохион байгуулалт, чиг үүрэг

2.1. Системийн үйл ажиллагааг Гамшиг судлалын үндэсний хүрээлэн чиглүүлж, мэдээллийг бүртгэх, засварлах үйл ажиллагааг төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан хаагчид хариуцна.

2.2. Системийн үндсэн зохицуулагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. Системийг хөгжүүлэх, бүрдүүлэх, харилцан ашиглах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

2.2.2. Системийн үндсэн, дэд бүрдүүлэгч болон энэ журмын 1.2-т заасан бусад хэрэглэгчийн хандалтын эрхийг баталгаажуулах;

2.2.3. Системийн хөгжүүлэлт, хадгалалт, нууцлал, нөөцлөлттэй холбоотой асуудлаар тоног төхөөрөмж, программ хангамж, ашиглалт, үйлчилгээнд шаардлагатай зардлын тооцоог Онцгой байдлын ерөнхий газарт танилцуулж шийдвэрлүүлнэ;

2.2.4. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийн бүрдүүлэлтэд хяналт тавих, баталгаажуулах, статистик мэдээлэл гаргах;

2.2.5. Системийн найдвартай, аюулгүй ажиллагааг ханган ажиллахад шаардлага бүхий техник хэрэгсэл, программ хангамжийн системийг сайжруулах, өргөжүүлэх санал гаргаж шийдвэрлүүлэх;
2.2.6. Нууцлал бүхий мэдээллийг оруулах, бүрдүүлэх, хадгалах болон системийн нөөцлөлт, нууцлалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
2.2.7. Хэрэглэгчийн хандалтын эрх үүсгэх, хязгаарлах, энгийн хэрэглэгчийн хандалтын эрхийн ангилалд зөвшөөрөгдөх мэдээллийг тохируулах;
2.2.8. Системийг онцгой байдлын байгууллагын ашиглаж буй бусад систем, өгөгдлийн сантай уялдуулах;
2.2.9. Системийн үндсэн хэрэглэгчдийг бэлтгэх, сургаж дадлагажуулах ажлыг Онцгой байдлын байгууллагын сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулж, зохион байгуулна;
2.2.10. Үндсэн хэрэглэгч нараас системийн үйл ажиллагаа, ашиглалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргуулж Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулна;
2.3. Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн чиг үүрэг
2.3.1. Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дуудлага, мэдээлэл хүлээн авах, бүртгэх зориулалт бүхий “EIN” системийг “Гамшиг, түргэн тусламжийн дуудлага мэдээллийн бүртгэл, тээврийн хэрэгслийн хяналтын дундын мэдээллийн дэд систем”-тэй харилцан холболтыг хийх, бүртгэгдсэн гамшиг, аюулт үзэгдэл, осол, түргэн тусламжийн мэдээллийг бодит цагийн хугацаанд хуулбарлах, засварлах, шинэчлэх,
2.3.2. “Гамшиг, түргэн тусламжийн дуудлага мэдээллийн бүртгэл, тээврийн хэрэгслийн хяналтын дундын мэдээллийн дэд систем”-ээр дамжуулан тээврийн хэрэгслийн байршил, бусад шаардлагатай мэдээ, мэдээллийг харах;

**2.4. Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн чиг үүрэг**

2.4.1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, мэдээ мэдээлэлтэй танилцах, ашиглах;
2.4.2. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гамшгийн тохиолдол бүрт хяналт тавьж мэдээ, мэдээллийг бүрэн гүйцэт оруулахыг бүсийн төвийн Онцгой байдлын газраас шаардах;
2.4.3. “Гамшиг аюулт үзэгдэл, ослын бүртгэл, хохирол, хэрэгцээний мэдээллийн систем”-ээр дамжуулан улсын хэмжээний шуурхай ажиллагааны тээврийн хэрэгслийн байршил, хөдөлгөөнийг хянах, чиглүүлэх;

**2.5. Бүсийн төв, Онцгой байдлын газрын чиг үүрэг**

2.5.1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, сэдэвчилсэн мэдээлэлтэй танилцах, ашиглах;
2.5.2. Бүсийн хэмжээнд бүртгэгдсэн гамшгийн тохиолдол бүрт хяналт тавьж мэдээ, мэдээллийг бүрэн гүйцэт оруулахыг харьяа Онцгой байдлын газар, хэлтсээс шаардах.
2.5.3. “Гамшиг, түргэн тусламжийн дуудлага мэдээллийн бүртгэл, тээврийн хэрэгслийн хяналтын дундын мэдээллийн систем”-д гамшгийн дуудлага мэдээллийг тухай бүр бүртгэх, засварлах, шинэчлэх,
2.5.4. Бүсийн хэмжээнд шуурхай ажиллагааны тээврийн хэрэгслийн байршил, хөдөлгөөнийг хянах, чиглүүлэх,
2.5.5. “Гамшиг аюулт үзэгдэл, ослын бүртгэл, хохирол, хэрэгцээний мэдээллийн систем”-д гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан зардал, шуурхай үнэлгээний мэдээллийг оруулах, тохиолдлын улмаас учирсан хохирол, хэрэгцээг тогтоолгуулж оруулах;

**2.6. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын анги, салбарын чиг үүрэг**

2.6.1. Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, сэдэвчилсэн мэдээлэлтэй танилцах, ашиглах;
2.6.2. Аймгийн хэмжээнд шуурхай ажиллагааны тээврийн хэрэгслийн байршил, хөдөлгөөнийг хянах, чиглүүлэх;
2.6.3. “Гамшиг, түргэн тусламжийн дуудлага мэдээллийн бүртгэл, тээврийн хэрэгслийн хяналтын дундын мэдээллийн систем”-д гамшгийн дуудлага мэдээллийг тухай бүр бүртгэх, засварлах, шинэчлэх;
2.6.4. “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, хохирол, хэрэгцээний мэдээллийн систем”-д гамшгийн үед үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан зардал, шуурхай үнэлгээний мэдээллийг оруулах, тохиолдлын улмаас учирсан хохирлыг тогтоолгуулж оруулах;

**Гурав. Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн ашиглалт**

3.1. Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийг дараах зорилгоор ашиглана. Үүнд:

3.1.1. Болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээлэл, нийгэм эдийн засгийн суурь статистик мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах бусад төлөвлөлтөд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх, мэдээлэл солилцох;

3.1.2. Аймаг, нийслэл, сумын нутаг дэвсгэрт тохиолдсон гамшгийн хохирол, хэрэгцээг холбогдох талууд "Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам"-ийн дагуу учирсан хохирлыг үнэлэн үнэн бодит мэдээллийг бүрдүүлэх;

3.1.3. Гамшгийн статистик мэдээлэл, үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, цаашид гарч болзошгүй аюулыг тооцоолох, шуурхай шийдвэр гаргах, үр дүнг танилцуулах;

3.1.4. Гамшгаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажилд ашиглах.

3.1.5. Гадаад болон дотоодын гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах бодлого хөтөлбөрийн хүрээнд олон улстай мэдээлэл солилцох

3.1.6. Бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт тус системийн мэдээллийг нээлттэй ашиглана.

**Дөрөв: Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн бүрдүүлэлт, ашиглалтад тавигдах шаардлага**

4.1. Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн ашиглалтад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

4.1.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар, арга зүйн дагуу мэдээллийг бүртгэсэн байх,

4.1.2. Гамшгийн статистик мэдээллийг гамшгийн нэгдсэн кодчиллын дагуу бүртгэсэн байх,

4.1.3. Гамшгийн улмаас учирсан хохирлыг баталгаажуулан актыг хавсаргасан байх,

4.1.4. Гамшгийн үед үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дэлгэрэнгүй протокол бичиж оруулсан байх,

**Тав: Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн найдвартай ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалт**

5.1. Системийн найдвартай ажиллагаа, өгөгдлийн сангийн хадгалалт, хамгаалалт, нөөцлөлт, нууцлалыг Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Мэдээллийн технологи, инновацын төв хариуцна;

5.2. Гамшгийн статистик мэдээллийн сан нь үндсэн болон нөөц сервер, нөөцлөлтийн программ хангамжтай байна;

5.3. Системийн нөөц хувилбарын систем нь үндсэн системтэйгээ адил түвшний хүчин чадал бүхий сервертэй байна;

5.4. Системийн нөөц хувилбарыг системээс систем рүү гэсэн зарчмаар нөөцлөн хадгална;

5.5. Системийн нөөцлөлтийн ажиллагааг долоо хоног бүрийн Лхагва гарагийн 04:00 цагт хийх ба нөөцлөлт хэвийн хийгдэж буй эсэхийг 14 хоног тутам шалгаж тэмдэглэл хөтөлнө;

5.6. Системд оруулсан өгөгдөл, мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдөр бүрэн нөөцөлж хадгална;

5.7. Системийн нөөцлөлтийг Онцгой байдлын ерөнхий газрын серверийн өрөөнд байрлах зориулалтын хадгалах төхөөрөмжид хадгална;

5.8. Мэдээллийн сангийн нууцлал бүхий мэдээллийг зохих хууль тогтоомжийн дагуу хүлээн авах, мэдээллийн санд оруулах, ашиглах, дамжуулах ажиллагааг хэрэгжүүлнэ;

5.9. Бусад байгууллагатай мэдээлэл харилцан солилцох, системд хандах эрхийг олгох, холболт болон сүлжээний нууцлалд хамаарах асуудлыг гэрээгээр зохицуулна;

5.10. Системийн хэрэглэгч өөрийн нэвтрэх нэр, нууц үгээ бусдад мэдэгдсэн, алдсан байж болзошгүй тохиолдолд нууц үгээ заавал өөрчилнө.

**Зургаа: Хориглох**

6.1. Санаатай болон санамсаргүйгээр системийн үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

6.2. Системийн мэдээ, мэдээллийг арилжааны зорилгоор ашиглах, ашиглуулахыг хориглоно.

6.3. Нэвтрэх нэр, нууц үгийг системийн хандалтын эрхгүй албан тушаалтанд дамжуулахыг хориглоно.

## Долоо: Хариуцлага

7.1. Системийн администратор/ үндсэн зохицуулагч нь журамд заасан чиг үүргээ биелүүлээгүй хэрэглэгчийн эрхийг хязгаарлана.

-o0o-

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны .1. дугаар сарын 10 .-ны өдрийн
А/102 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**Гамшгийн статистик, хохирол, хэрэгцээ, мэдээллийн нэгдсэн системийн хэрэглэгчдийн жагсаалт**

1.1. "Гамшиг аюулт үзэгдэл, ослын бүртгэл, хохирол, хэрэгцээний дундын мэдээллийн систем"-ийн хэрэглэгчид

| № | Бүс | Газар, хэлтэс | Албан тушаал | Нэвтрэх нэр |
|---|---|---|---|---|
| Администратор | | | | |
| 1 | Онцгой байдлын ерөнхий газар | Орон зайн мэдээлэл технологийн тасаг | Тасгийн дарга | MNSITD01 |
| 2 | | | Орон зайн мэдээлэл технологийн тасгийн мэргэжилтэн | MNSITD02 |
| 3 | | | | MNSITD03 |
| 4 | | | | MNSITD04 |
| 5 | | ГСҮХ | Мэдээллийн технологи, инновацын төвийн дарга | NIDR02 |
| Мэдээ засварлагч | | | | |
| 6 | Үндэсний аврах бригад | | Холбооны тусгай бүлгийн дарга | NRB03 |
| 7 | | | Бүлгийн дарга нар | NRB04 |
| 8 | | | | NRB05 |
| 9 | Нийслэлийн онцгой байдлын газар | Нийслэлийн онцгой байдлын газар | Мэдээллийн аюулгүй байдал, программ хангамж хариуцсан мэргэжилтэн | NOBG04 |
| 10 | | | Эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн | NOBG08 |
| 11 | | Нийслэлийн аврах ангийн бүлгийн дарга | Бүлгийн дарга | NOBG105 |
| 12 | | Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч | NOBG11 |
| 13 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | NOBG12 |
| 14 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG13 |
| 15 | | | ГТУА 64 дүгээр ангийн захирагч | NOBG14 |
| 16 | | Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч | NOBG21 |
| 17 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | NOBG22 |
| 18 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG23 |
| 19 | | | ГТУА 80 дугаар ангийн захирагч | NOBG24 |
| 20 | | Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, байцаагч | NOBG31 |
| 21 | | | Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн | NOBG32 |
| 22 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG33 |
| 23 | | | ГТУА 18 дугаар ангийн захирагч | NOBG34 |
| 24 | | Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, байцаагч | NOBG41 |
| 25 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | NOBG42 |
| 26 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG43 |
| 27 | | | ГТУА 35 дугаар ангийн захирагч | NOBG44 |
| 28 | | | ГТУА 63 дугаар ангийн захирагч | NOBG45 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 29 | | Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, байцаагч | NOBG51 |
| 30 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | NOBG52 |
| 31 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG53 |
| 32 | | | ГТУА 28 дугаар ангийн захирагч | NOBG54 |
| 33 | | Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, байцаагч | NOBG61 |
| 34 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | NOBG62 |
| 35 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG63 |
| 36 | | | ГТУА 11 дүгээр ангийн захирагч | NOBG64 |
| 37 | | | ГТУА 26 дугаар ангийн захирагч | NOBG65 |
| 38 | | | ГТУА 29 дүгээр ангийн захирагч | NOBG66 |
| 39 | | Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, байцаагч | NOBG71 |
| 40 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | NOBG72 |
| 41 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG73 |
| 42 | | | ГТУА 34 дүгээр ангийн захирагч | NOBG74 |
| 43 | | | ГТУА 74 дүгээр ангийн захирагч | NOBG75 |
| 44 | | Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, байцаагч | NOBG81 |
| 45 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | NOBG82 |
| 46 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG83 |
| 47 | | | ГТУА 14 дүгээр ангийн захирагч | NOBG84 |
| 48 | | | ГТУА 30 дугаар ангийн захирагч | NOBG85 |
| 49 | | | ГТУА 65 дугаар ангийн захирагч | NOBG86 |
| 50 | | Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, байцаагч | NOBG91 |
| 51 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | NOBG92 |
| 52 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | NOBG93 |
| 53 | | | ГТУА 10 дугаар ангийн захирагч | NOBG94 |
| 54 | | Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | HOA02 |
| 55 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | HOA03 |
| 56 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | HOA04 |
| 57 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | HOA05 |
| 58 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | HOA06 |
| 59 | | | ГТУА 38 дугаар ангийн захирагч | HOA38 |
| 60 | | | ГТУА 48 дугаар ангийн захирагч | HOA48 |
| 61 | | | ГТУА 70 дугаар ангийн захирагч | HOA70 |
| 62 | | | Эрэн хайх, аврах ангийн захирагч | HOA105 |
| 63 | | Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | BAU02 |
| 64 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | BAU03 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 65 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | BAU04 |
| 66 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | BAU05 |
| 67 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | BAU06 |
| 68 | | | ГТУА 31 дүгээр ангийн захирагч | BAU31 |
| 69 | | Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | GAA02 |
| 70 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | GAA03 |
| 71 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | GAA04 |
| 72 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | GAA05 |
| 73 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | GAA06 |
| 74 | | | ГТУА 59 дүгээр ангийн захирагч | GAA59 |
| 75 | | Завхан аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | ZAA02 |
| 76 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | ZAA03 |
| 77 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | ZAA04 |
| 78 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | ZAA05 |
| 79 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | ZAA06 |
| 80 | | | ГТУА 39 дүгээр ангийн захирагч | ZAA39 |
| 81 | | | ГТУА 43 дугаар ангийн захирагч | ZAA43 |
| 82 | | | ГТУА 57 дугаар ангийн захирагч | ZAA57 |
| 83 | | | Эрэн хайх, аврах бүлгийн дарга | ZAA105 |
| 84 | | Увс аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | UVS02 |
| 85 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | UVS03 |
| 86 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | UVS04 |
| 87 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | UVS05 |
| 88 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | UVS06 |
| 89 | | | ГТУА 41 дүгээр ангийн захирагч | UVS41 |
| 90 | | | ГТУА 60 дугаар ангийн захирагч | UVS60 |
| 91 | Хойд бүс | Хойд бүсийн төв-Орхон аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | ORA02 |
| 92 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | ORA03 |
| 93 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | ORA04 |
| 94 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | ORA05 |
| 95 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | ORA06 |
| 96 | | | ГТУА 56 дугаар ангийн захирагч | ORA56 |
| 97 | | | ГТУА 58 дугаар ангийн захирагч | ORA58 |
| 98 | | | ГТУА 81 дүгээр ангийн захирагч | ORA81 |
| 99 | | | Эрэн хайх, аврах ангийн захирагч | ORA105 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 100 | | Архангай аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | ARA02 |
| 101 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | ARA03 |
| 102 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | ARA04 |
| 103 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | ARA05 |
| 104 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | ARA06 |
| 105 | | | ГТУА 51 дүгээр ангийн захирагч | ARA51 |
| 106 | | | Эрэн хайх, аврах салбарын дарга | ARA105 |
| 107 | | Булган аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | BUA02 |
| 108 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | BUA03 |
| 109 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | BUA04 |
| 110 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | BUA05 |
| 111 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | BUA06 |
| 112 | | | ГТУА 20 дугаар ангийн захирагч | BUA20 |
| 113 | | | ГТУА 50 дугаар ангийн захирагч | BUA50 |
| 114 | | | Эрэн хайх, аврах салбарын дарга | BUA105 |
| 115 | | Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | DAA02 |
| 116 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | DAA03 |
| 117 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | DAA04 |
| 118 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | DAA05 |
| 119 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | DAA06 |
| 120 | | | ГТУА 22 дугаар ангийн захирагч | DAA22 |
| 121 | | | ГТУА 54 дүгээр ангийн захирагч | DAA54 |
| 122 | | | ГТУА 55 дугаар ангийн захирагч | DAA55 |
| 123 | | | Эрэн хайх, аврах ангийн захирагч | DAA105 |
| 124 | | Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | SEA02 |
| 125 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | SEA03 |
| 126 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | SEA04 |
| 127 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | SEA05 |
| 128 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | SEA06 |
| 129 | | | ГТУА 19 дүгээр ангийн захирагч | SEA19 |
| 130 | | | ГТУА 40 дүгээр ангийн захирагч | SEA40 |
| 131 | | | ГТУА 36 дугаар ангийн захирагч | SEA36 |
| 132 | | | ГТУА 61 дүгээр ангийн захирагч | SEA61 |
| 133 | | | Эрэн хайх, аврах ангийн захирагч | SEA105 |
| 134 | | | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | TUV02 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 135 | | Төв аймгийн Онцгой байдлын газар | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | TUV03 |
| 136 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | TUV04 |
| 137 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | TUV05 |
| 138 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | TUV06 |
| 139 | | | ГТУА 24 дүгээр ангийн захирагч | TUV24 |
| 140 | | | Эрэн хайх, аврах салбарын дарга | TUV105 |
| 141 | | Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | HUV02 |
| 142 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | HUV03 |
| 143 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | HUV04 |
| 144 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | HUV05 |
| 145 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | HUV06 |
| 146 | | | ГТУА 27 дугаар ангийн захирагч | HUV27 |
| 147 | | | ГТУА 46 дугаар ангийн захирагч | HUV46 |
| 148 | | | ГТУА 69 дүгээр ангийн захирагч | HUV69 |
| 149 | | | Эрэн хайх, аврах салбарын дарга | HUV105 |
| 150 | Зүүн бүс | Зүүн бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | DOA02 |
| 151 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | DOA03 |
| 152 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | DOA04 |
| 153 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | DOA05 |
| 154 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | DOA06 |
| 155 | | | ГТУА 52 дугаар ангийн захирагч | DOA52 |
| 156 | | | ГТУА 53 дугаар ангийн захирагч | DOA53 |
| 157 | | | ГТУА 53 дугаар ангийн захирагч | DOA62 |
| 158 | | | Эрэн хайх, аврах ангийн захирагч | DOA105 |
| 159 | | Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | SBA02 |
| 160 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | SBA03 |
| 161 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | SBA04 |
| 162 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | SBA05 |
| 163 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | SBA06 |
| 164 | | | ГТУА 15 дугаар ангийн захирагч | SBA15 |
| 165 | | | ГТУА 47 дугаар ангийн захирагч | SBA47 |
| 166 | | | Эрэн хайх, аврах салбарын дарга | SBA105 |
| 167 | | | Эрэн хайх, аврах бүлгийн дарга | SBA106 |
| 168 | | Хэнтий аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | HEA02 |
| 169 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, | HEA03 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | |
| 170 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | HEA04 |
| 171 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | HEA05 |
| 172 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | HEA06 |
| 173 | | | ГТУА 32 дугаар ангийн захирагч | HEA32 |
| 174 | | | ГТУА 42 дугаар ангийн захирагч | HEA42 |
| 175 | | | ГТУА 49 дүгээр ангийн захирагч | HEA49 |
| 176 | | | Эрэн хайх, аврах салбарын дарга | HEA105 |
| 177 | Өмнөд бүс | Өмнөд бүсийн төв-Өмнөговь аймгийн | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | UMA02 |
| 178 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | UMA03 |
| 179 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | UMA04 |
| 180 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | UMA05 |
| 181 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | UMA06 |
| 182 | | | ГТУА 21 дүгээр ангийн захирагч | UMA21 |
| 183 | | | ГТУА 44 дүгээр ангийн захирагч | UMA44 |
| 184 | | | ГТУА 66 дугаар ангийн захирагч | UMA66 |
| 185 | | | ГТУА 67 дугаар ангийн захирагч | UMA67 |
| 186 | | | Эрэн хайх, аврах салбарын дарга | UMA105 |
| 187 | | Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | BHA02 |
| 188 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | BHA03 |
| 189 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | BHA04 |
| 190 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | BHA05 |
| 191 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | BHA06 |
| 192 | | | ГТУА 16 дугаар ангийн захирагч | BHA16 |
| 193 | | Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | GSA02 |
| 194 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | GSA03 |
| 195 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | GSA04 |
| 196 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | GSA05 |
| 197 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | GSA06 |
| 198 | | | ГТУА 37 дугаар ангийн захирагч | GSA37 |
| 199 | | | Эрэн хайх, аврах бүлгийн дарга | GSA105 |
| 200 | | Дорноговь аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | DGA02 |
| 201 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | DGA03 |
| 202 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | DGA04 |
| 203 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | DGA05 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 204 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | DGA06 |
| 205 | | | ГТУА 17 дугаар ангийн захирагч | DGA17 |
| 206 | | | ГТУА 23 дугаар ангийн захирагч | DGA23 |
| 207 | | | ГТУА 33 дугаар ангийн захирагч | DGA33 |
| 208 | | Дундговь аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | DUA02 |
| 209 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | DUA03 |
| 210 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | DUA04 |
| 211 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | DUA05 |
| 212 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | DUA06 |
| 213 | | | ГТУА 25 дугаар ангийн захирагч | DUA25 |
| 214 | | | Эрдэнэдалай сум дахь эрэн хайх аврах салбарын дарга | DUA105 |
| 215 | | Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | UVA02 |
| 216 | | | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | UVA03 |
| 217 | | | Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | UVA04 |
| 218 | | | Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч | UVA05 |
| 219 | | | Гал түймрийн улсын хяналтын байцаагч | UVA06 |
| 220 | | | ГТУА 12 дугаар ангийн захирагч | UVA12 |
| 221 | | | ГТУА 45 дугаар ангийн захирагч | UVA45 |

1.2. “Гамшиг, түргэн тусламжийн дуудлага мэдээллийн бүртгэл, тээврийн хэрэгслийн хяналтын дундын мэдээллийн систем”-ийн хэрэглэгчид

| № | Анги, салбарын нэр | Албан тушаал | Хэрэглэгч |
|---|---|---|---|
| 1. | Гамшиг судлалын үндэсний хүрээлэн | Мэдээллийн технологи, инновацын төвийн дарга | NIDR02 |
| 2. | Үндэсний аврах бригад | Шуурхай удирдлагын зохицуулагч | NRB01 |
| 3. | | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NRB02 |
| 4. | Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв | Шуурхай удирдлагын зохицуулагч | DMEC01 |
| 5. | | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | DMEC02 |
| 6. | **Нийслэлийн онцгой байдлын газар** | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн | NOBG01 |
| 7. | | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG02 |
| 8. | Мэдээлэл шуурхай удирдлагын төв | Ерөнхий зохицуулагч | MSHUT01 |
| 9. | | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | MSHUT02 |
| 10. | Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG12 |
| 11. | | | |
| 12. | Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG21 |
| 13. | Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG31 |
| 14. | Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG41 |
| 15. | Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG51 |
| 16. | Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG61 |
| 17. | Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG71 |
| 18. | Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG81 |
| 19. | Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | NOBG91 |
| 20. | **Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар** | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | HOA11 |
| 21. | Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | BAU32 |
| 22. | Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | GAA60 |
| 23. | Завхан аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | ZAA11 |
| 24. | Увс аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | UVS61 |
| 25. | **Хойд бүсийн төв-Орхон аймгийн Онцгой байдлын газар** | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | ORA11 |
| 26. | Архангай аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | ARA11 |
| 27. | Булган аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | BUA11 |
| 28. | Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | DAA11 |
| 29. | Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | SEA11 |
| 30. | Төв аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | TUV11 |

| | | | |
|---|---|---|---|
| 31. | Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | HUV11 |
| 32. | **Зүүн бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газар** | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | DOA13 |
| 33. | Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | SBA11 |
| 34. | Хэнтий аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | HEA11 |
| 35. | Өмнөд бүсийн төв-Өмнөговь аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | UMA10 |
| 36. | Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | BHA17 |
| 37. | Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | GSA11 |
| 38. | Дорноговь аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | DGA34 |
| 39. | Дундговь аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | DUA11 |
| 40. | Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан оператор | UVA04 |